

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ДАВААГИЙН ЦЭНДСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах							
1	Эрсдэлийн мэдээллийн сангийн баяжилтыг нэмэгдүүлсэн байна (Зорчигч, ААН, бараа, тээврийн хэрэгсэл зэрэг).	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%		01.01-06.05	96
2	Гаалийн хяналтад эрсдэл тооцож дүн шинжилгээ, судалгаа хийж, үр дүнг тооцно	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	Тайлант хугацаанд системийн хэмжээнд эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах 7 судалгааг хийж гүйцэтгэсэн: · Гадаад худалдааны орчны судалгаа 2023; · БТКУС-ийн 8703 кодоод хамаарах суудлын автомашины бүрдүүлэлт; · Гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилт; · Эрсдэлийн шалгуурын судалгаа; · Гаалийн мэдүүлгийн шалгалтын үр дүнгийн судалгаа; · Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчдийн судалгаа; · ЗҮГГ-т аж ахуйн нэгж, иргэдийн “итгэмжлэл олгон, төлөөлөгчөөр дамжуулан” хийсэн гаалийн бүрдүүлэлтийн дүн шинжилгээ. Үүний үр дүнд Татварын ерөнхий газартай улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлийг бууруулах, бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах аж ахуйн нэгж, иргэнийг сонгох, шалгалтын үр дүнгийн саналаар	01.01-06.05	95
3	Эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	БДШГ, БАҮХ, ХЦХ, БНТ болон харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт” болон хэлтсийн чиг үүргийн хүрээнд хийсэн судалгааг үндэслэн хяналтын хуудас боловсруулж, ААН-ийг БТКУС код, гаалийн газар, хороотой уялдуулж, зохих шалгуурт оруулж, эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийсэн.	01.01-06.05	97
4	Бараанд хийх бичиг баримтын болон биет шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээг 30 хувиар нэмэгдүүлж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	90%	50%	ЭУХ-ээс хийсэн судалгаа, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн эрсдэл тооцсон дүн шинжилгээ, эрсдэлийн шалгуурын хүсэлтийг хүлээн авч, 95 хяналтын хуудсаар Эрсдэлийн удирдлагын программд 483 шалгуур үзүүлэлтийг оруулсан. ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодтой нягт уялдаа холбоотой ажилласнаар бичиг баримтын болон бараанд хийх	01.01-06.05	92

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
	эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг 65 хувьд хүргэнэ.				шалгалтаас нийт бүрдүүлэлтийн 63 хувийг чөлөөлсөн үр дүнд хүрч, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа зардлыг бууруулж, хууль ёсны худалдааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлсэн.		
5	Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	· ЭУХ-ээс хийсэн 2018-2022 оны Гадаад худалдааны орчны судалгааны үр дүнгээр гадаад худалдаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгжийн хууль сахилтыг тодорхойлох энгийн загварыг боловсруулсан. Загварыг 2023 оны бүрдүүлэлтийн мэдээлэлтэй уялдуулж, алгоритмыг шинэчилсэн. · Гаалийн байгууллагын 2024 оны үндсэн гурван зорилтын нэг болох “Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд гадаад худалдаанд оролцогч Хуулийн этгээдийн хууль сахилтын түвшинг тогтоох зайлшгүй шаардлагатай тул Хуулийн этгээдийн хууль сахилтын түвшинг тодорхойлох загварыг боловсруулан Мэдээллийн технологийн газарт программ хийлгэхээр программын бодлогын даалгавар хүргүүлсэн.	01.01-06.05	91
6	Агаарын тээврийн зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож ажиллах боломжийг бүрдүүлнэ. Төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд Эрсдэлтэй зорчигчийг онилох системийн хөгжүүлэлтийг хийсэн байна. Зорчигчийн онилгооны төвтэй хамтран ажилласан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	· Засгийн газрын 2023 оны “Журам, бүтэц, орон тоо батлах тухай” 174 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталсан. Журмын 5.8-д “Төв нь хууль хяналтын байгууллагатай байгуулсан гэрээ, санамж бичгийн хүрээнд мэдээллийн сан болон бусад холбогдох баримтын талаар мэдээлэл солилцоно” гэж заасан. Үүний дагуу ГЕГ, Зорчигчийн мэдээллийн төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, хамтран ажиллахаар төлөвлөсөн. · Зорчигчийн мэдээллийн төвтэй үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, эрсдэл бүхий зорчигчийн мэдээлэл солилцох, хил дамнасан мөнгө угаах гэмт хэргийн харилцан хамааралтай талуудыг таньж тогтоох, худалдааны луйвар илрүүлэх болон бусад чиглэлээр хамтран ажиллах болон харилцан солилцох мэдээллийн жагсаалтыг хэлэлцэх уулзалт хийж, гэрээний төслийг боловсруулж Зорчигчийн мэдээллийн төвд хүргүүлсэн. · Гэрээний төсөлд Зорчигчийн мэдээллийн төвөөс санал ирүүлсэн бөгөөд гэрээний төсөлтэй танилцаж, холбогдох нэгжүүдээс санал аван гэрээний төслийг эцэслэн боловсруулан, Гаалийн ерөнхий газар, Зорчигчийн мэдээллийн төвтэй 2024.05.16-ны өдөр “Мэдээлэл харилцан солилцох тухай 07/24 дугаар гэрээ”-г байгуулсан.	01.01-06.05	100
7	Хяналтын төлөвийн хэрэгжилт, төлөв солилтын шалтгаан үр дүнг тооцно.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	75%	50%	· Тайлант хугацаа (2024.01.01-06.10)-нд хийгдсэн 505,235 гаалийн бүрдүүлэлт (импортын 180,613 (35.7%), экспортын 324,622 (64.3%))-ийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23%-аар өссөн байна. · Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн статистик үзүүлэлттэй байна (2023.01.01-	01.01-06.05	95

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					06.10: 387,313 бүрдүүлэлт хийгдсэнээс 25.6% нь “Ногоон” төлөвд (99,249 бүрдүүлэлт), 34% нь “Улбар шар” төлөвд (131,705 бүрдүүлэлт) тус тус сонгогдсон байна). · Нийт бүрдүүлэлтээс 1,294 гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь нийт бүрдүүлэлтийн 0.3%-ийг эзэлж, 717 мэдүүлгийг “баталгаажихаас өмнө”, 577 мэдүүлгийг “баталгаажуулсны дараа” тус тус засварт буцаасан байна. · Импортын гаалийн 180,613 бүрдүүлэлтээс 3.8% нь “ногоон” (6849 бүрдүүлэлт), 12.6% нь “улбар шар” (22,803 бүрдүүлэлт) хяналтын төлөвд тус тус сонгогдож, бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь 16.4%-д хүрсэн байна. · Экспортын гаалийн 324,622 бүрдүүлэлтээс 22.6% нь “ногоон” (73,510 бүрдүүлэлт), 66.4% нь “улбар шар” (215,697 бүрдүүлэлт) хяналтын төлөвд тус тус сонгогдож, бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь 89.1%-д хүрсэн байна. · Тайлант хугацаанд хийгдсэн 505,235 бүрдүүлэлтээс хяналтын “ногоон” төлөвийн 9, “улбар шар” төлөвийн 27 буюу нийт 36 мэдүүлгийн төлөвийг “Улаан” төлөвд өөрчилсөн нь өнгөрсөн оны үеэс 6 дахин буурсан байна (2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн 387313 бүрдүүлэлтийн хяналтын “ногоон” төлөвийн 20, “улбар шар” төлөвийн 193 буюу нийт 213 мэдүүлгийн төлөвийг өөрчилжээ). · Тайлант хугацаа (2024.06.10)-нд хяналтын “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 36 мэдүүлгийг “Улаан” төлөвд өөрчилсөн байна. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (2023.06.10: “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 213 мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн) төлөв өөрчлөлт 83 хувиар буурсан үзүүлэлттэй байна.		
8	Эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах ААНБ жагсаалтыг БДШГ-т хүргүүлж хамтран ажилласан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	75%	50%	· “Эрсдэлийн удирдлага”-д суурилсан гаалийн хяналтын үр дүнг үндэслэн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулахаар гаалийн газар, хороодоос ирүүлсэн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”, “Шалгалтын үр дүнгийн санал”, “Зөрчилд холбогдсон байдал”, “Эрсдэлийн дүн шинжилгээний үр дүн” болон “Улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлт орчныг тодорхойлох” судалгаа зэргийг үндэслэн БДШГ-т 6 удаагийн дотоод зурвасаар 302 ААН-ийн жагсаалтыг хүргүүлсэн.	01.01-06.05	100
9	Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийж, Мэргэжлийн зөвлөлд танилцуулсан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	75%	60%	· Судалгааны тайланг ГЕГ-ын дарга, дэд даргад танилцуулж, чиглэл авч 2024.05.13-ны өдрийн онлайн хуралд танилцуулга хийсэн. ГЗДАС-ийн Худалдааг хөнгөвчлөх дэд талбарт судалгаа болон танилцуулгыг байршуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан (хандалтын тоо: 190). · Судалгааны ажил нь Хураангуй, Судалгааны арга зүй, Онол, арга зүйн үндэслэл, Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байдал, Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа, Дүгнэлт, Санал,	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					Хавсралтыг оролцуулсан долоон бүлэг, зургаан дэд бүлэг, долоон дэд хэсэг, 17 зураг, 40 хүснэгт, 5 хавсралтаас бүрдэнэ (80 хуудастай). Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх таван судалгаа, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан хугацаанд хийгдсэн 17,352 гаалийн мэдүүлэг ба 100,152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266,309 мянган өгөгдөл/мэдээллийг судалгаанд хамруулсан. · Гуравдугаар бүлэгт сонгон авсан хугацаанд гаалийн газар, хяналтын бүсэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг КАИС-ийн таван дэд программаас татан авч, харьцуулан, хилийн гааль дээр, хилээс гүний гаалийн хяналтад илгээн, барааг эзэнд олгох хүртэлх цаг хугацааг тооцоолон, өмнөх судалгаатай харьцуулан цаг хугацааны өөрчлөлтийг гаргасан. · Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой долоон төрлийн үйл ажиллагааг ажиглагдсан утга тус бүрээр Статистикийн “Дундаж, Медиан, Хамгийн их, Хамгийн бага утга, Стандарт хазайлт, Хазайлт, Муруйлт, Нийлбэр” утгаар шинжилгээ хийсэн. · Гаалийн байгууллагын мэдээллийн автоматжуулсан системд 2023 оноос шинэчлэл хийгдэж тээврийн хэрэгслийн программд автотээврийн хэрэгслээс гадна агаарын тээврийн хэрэгсэл, төмөр замын тээврийн хэрэгслээр орсон барааны бүртгэл бүрэн хэмжээгээр хийдэг болсон. Энэ нь өмнө нь асуулгын хуудсаар ачилт бүрийн хугацааг тэмдэглэн, дахин хөрвүүлж байсантай харьцуулахад томоохон ахиц дэвшил гарсан гэж үзэж байна. · ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад “Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн лабораторийн шинжилгээ” зэрэг үйл ажиллагаа бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ. Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг 2019 оны судалгаатай харьцуулахад зөрүүтэй байгаа нь өгөгдөл/мэдээлэл цуглуулсан, боловсруулсан аргачлалын хувьд ялгаатай байгаатай холбоотой. Үүнтэй уялдуулан хоёр судалгааны ижил болон ялгаатай талыг харьцуулан харуулсан. · Шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд 1,993.5 минут зарцуулсныг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар буурсан. Тус бууралтад нөлөөлсөн гол үе шат нь бичиг баримтын шалгалт 64 хувиар буурсантай холбоотой. Голч утга (медиан)-аар авч үзэхэд 2023 онд 267.5 минут байгаа нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд үүнд хорио цээрийн шалгалтад 2023 онд зарцуулсан дундаж болох 841 минут/14 цагийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 136 минут/16 хувиар өссөн нь нөлөөлжээ. Шинжилгээний үр дүнд “Хорио цээрийн шалгалт болон ГУАБ		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					зөвшөөрөх” үе шат нь дундаж хугацаанаас хэт хазайлттай гарсан. Энэ нь тухайн үе шатанд тооцоолол хийхэд хүндрэл учруулах эрсдэлийг бий болгожээ. Бусад үе шатын хувьд 40-124 минут/0.7-2.06 цагаар буурсан байна. · Бүрдүүлэлтийн үе шат бүрээс онцгой ахиц дэвшил бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлэн цахим хэлбэрээр хийх болсонтой холбоотой юм. · “Татвар төлөх хугацаа” нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ба 2022 оны дунджаар 20 цаг, 19 минут; 2023 оны дунджаар 19 цаг 38 минут тус тус зарцуулсан. “Татвар төлөх хугацаа” нь гаалийн бүрдүүлэлтийн хугацааг нэмэгдүүлсэн байна. Учир нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй мэдүүлэгч нар бараагаа авахгүй удаж байгаа нь улаан төлөвт ХШ-ын ГУБ, улбар шар, ногоон төлөвт ХШ-ын ГУАБ, цаашлаад нийт хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. · Гаалийн хяналтын улбар шар болон ногоон төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлтийн хугацаа улаан төлөвтэй бараг ойролцоо гарсан нь “Татвар төлөх хугацаа” өндөр байгаатай холбоотой, нөгөөтэйгүүр барааны тоогоор харьцуулахад нэг болон олон нэр төрөлтэй эсэхээс үл хамаарч бичиг баримт болон бараанд хийх шалгалтад ижил хугацаа, эсхүл нэг нэр төрлийн бараанд илүү хугацаа зарцуулжээ.		
10	ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, ЗББНДБ, гаалийн газар, хороодтой хамтран ажиллана.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	35%	Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр ДГБ, НҮБ, нийт 29 мэдээ, тайлан, судалгаа болон бусад бодлогын баримт бичгийг ГЗДАС-ийн “Худалдааг хөнгөвчлөх” дэд талбарт байршуулан мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан (Хандалтын тоо 1,439). · Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөн ажлын хэсгийн тушаалыг шинээр батлуулсан бөгөөд гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. · Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн ажилд хяналт тавих зорилгоор Reform Tracker программыг ашиглаж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хуралтай хамтран ажиллах цахим уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтын үр дүнд Меркатор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө мөн Хямралын үед Худалдааг хөнгөвчлөхөд бэлэн байдлын үнэлгээний тайлан, үйл ажиллагаа зэргийг Reform tracker программд оруулж, ашиглаж эхэлсэн нь Худалдааг хөнгөвчлөх ажлын шинэчлэлтийг сайжруулах ахиц, дэвшил болсон.	01.01-06.05	97

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
11	Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Зүйл 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалт арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	80%	- ДГБ-ын “Меркатор” хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээний тайланг Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх, бусад арга хэмжээ, түүний дотор эрсдэлийн удирдлага, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөртэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажилласан. - Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр бүтэц орон тоог нэмэгдүүлж, өргөжүүлсэн. - Гаалийн үнэлгээ, барааны ангилал, бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр 14 албан хаагчийг Япон Улсын Токиогийн гаалийн төвд сургалтад хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн. - Бүрдүүлэлтийн дараах шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ДГБ-ын экспертүүдийн тусламжтайгаар Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам, Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх зааврын шинэчлэн найруулсан төслийг боловсруулсан. - Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр ДГБ-ын бүрдүүлэлтийн дараах шалгалт, барааны гарал үүслийн сургалт, мөн Олон улсын валютыг сангаас зохион байгуулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх сургалтад тус тус хамруулсан. - Бүрдүүлэлтийн дараах шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр тэдгээрт зориулсан тусгайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байна. - Энэ ажлын хүрээнд Эрсдэлийн удирдлагын хэлтсээс бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах 302 аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг хүргүүлж, харилцан мэдээлэл солилцон хамтарсан эрсдэл тооцон ажиллах үйл ажиллагааг хэвшүүлсэн. - ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Зүйл 7.5 Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ГХЯ-нд хүргүүлж, Монгол Улсын тус хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг болсон.	01.01-06.05	100
12	Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	70%	40%		01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
13	Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	70%	30%	- Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулах арга хэмжээний хүрээнд Монголын гааль цахим хуудсаар богино хэмжээний 8 бичлэг бэлтгэж, олон нийтэд мэдээлэл хүргүүлсэн. 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан "Менежментийн форум-2024" арга хэмжээнд оролцож, бизнес эрхлэгчдэд "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж" хөтөлбөрийн брошюр тараасан. Мөн Юнивишн, Юнител, Мобиком, Шангрила ХХК-ийн төлөөлөгчдөд хөтөлбөрийн талаар товч танилцуулга хийсэн. - ААН-ийн хууль сахилтын түвшинг тодорхойлж, Сайн гэж үнэлэгдсэн болон УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн. Говь ХК, Янмал ХХК-ийн менежерүүдэд биет уулзалтаар болон утсаар холбоо барьж өөрийн үнэлгээний хуудсыг хэрхэн нөхөн бичих талаар зөвлөгөө өгсөн.	01.01-06.05	100
Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
14	Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулсан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	60%	- ГЕГ-ын даргын 2022 оны А/343 дугаар тушаалаар “Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратеги”, хорио цээрийн болон гаалийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журмыг шинэчлэхээр ажиллаж байна. - Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулах төслийг боловсруулж, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод төслийг хүргүүлж холбогдох саналыг тусган, 6 удаагийн уулзалт хийж, эцсийн хувилбарыг боловсруулсан.	01.01-06.05	95
15	Эрсдэлийн удирдлагын чиглэлээр холбогдох бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	50%	Засгийн газрын 2023.05.17-ны өдрийн 178 дугаар тогтоолын биелэлтийг дараах заалтуудын дагуу Хуулийн хэлтэст сар бүр, Хяналт, бүрдүүлэлтийн газарт Нэгдүгээр улирал болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус тус гаргаж, цаг хугацаанд нь хүргүүлсэн: - Эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг эрчимжүүлж, мэдээлэл, бичиг баримтын болон бараа, тээврийн хэрэгсэлд хийх шалгалтад хамрагдах гаалийн бүрдүүлэлтийн тоог жил бүр 15 хувиар бууруулж, гадаад худалдааг хөнгөвчлөх, хилийн боомт дээр дараалал, бөөгнөрөл үүсгэхгүйн тулд бараа, тээврийн хэрэгслийг гүнийн гаалийн хяналтад шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах; - Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх; “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуй нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-д заасан аж ахуйн	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					нэгжид тавигдах шаардлагыг оновчтой болгох, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах. · Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 178 дугаар тогтоол , Гаалийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт зэрэг бодлогын бичиг баримт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зөвлөмжийн дагуу биелэлтийг гаргаж, цаг хугацаанд нь тайлагнасан.		
16	Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна. Тус хэлтэс томилогдсон албан хаагч ХАСУМ-ийг хуулийн хугацаанд гаргуулсан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	80%	ХАСХОМ мэдүүлсэнг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталгаажуулж, баталгааны маягтыг ЗУГ-т хүргүүлсэн.	01.01-06.05	100
17	Нэгжийн чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	· Нэгжийн гүйцэтгэлийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийхдээ ДГБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд үзүүлсэн үйл ажиллагааны зураглалын дагуу хийж гүйцэтгэсэн. Эрсдэлийн агуулгыг тодорхойлж, тус хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой давуу болон сул гарган ирсэн. Хэлтсийн үйл ажиллагаанд олон давуу тал байгаа ч үйл ажиллагааны уялдаа холбоо, тогтвор суурьшилтай хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хангалт зэрэг олон сул тал байна. · Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй хүчин хүчин зүйлийг “Бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг; Хүний нөөц; Мэдээллийн технологи” гэж төрөлжүүлэн, гарч болзошгүй 9 эрсдэлийг таньж, тогтоон эрсдэл гарах магадлал, түүний үр дагаврын оноог “3х3 Матриц”-ийн тусламжтай үнэлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг тэргүүлэх чиглэлийн, өндөр болон дунд эрсдэл тус бүрээр гаргасан. Эдгээр гурван хүчин зүйлийн хүрээнд 24 арга хэмжээг төлөвлөн, төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд: · Өмнөх жилүүдэд нэгжийн эрсдэлийг ерөнхий байдлаар тооцож байсан боловч, олон улсын стандартад үндэслэн эрсдэлийн агуулгыг тодорхойлохоос эхлэн түүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангах иж бүрэн судалгаа хийж байгаагүй. Энэ жилийн	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэхүү ажлыг тусгасан нь тус хэлтэс өөрийн эрсдэлт орчныг таньж, тодорхойлж, түүнийг бууруулах боломжийг гарган ирсэн нь үр дүнтэй ажил болсон. Нэгжийн үйл ажиллагаатай холбоотой · Эрсдэлийн агуулгыг тодорхойлж, тус хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 14 давуу тал, 10 сул талыг тодорхойлж, эрсдэлийн сан үүсгэн, түүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүний үр дүнд хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилан, өөрийн давуу талыг ашиглан, сул талаа бууруулахад дэмжлэг болсон. · <u>Мэдээллийн технологи (тэргүүлэх):</u> МТГ-тай хамтран ажиллаж, “Эрсдэлийн удирдлагын программ”-ын алдаатай ажиллаж байсан зарим дэд хэсгүүдийг сайжруулсан. “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж программ”-ын хувьд холбогдох өөрчлөлтүүдийг хийж байнгын холбоотой ажиллаж байна. Аж ахуйн нэгж, иргэний хууль сахилтыг үнэлэх программын бодлогын даалгавар боловсруулж, ХЦХ-тэй хамтран ажиллаж, хамтарсан эрсдэл тооцох боломжийг эрэлхийлж байна. · <u>Бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг (өндөр):</u> Худалдааг хөнгөвчлөх асуудал хариуцсан ГУАБ, ГУБ-ийн орон тоог нэмэх саналыг хүлээн аваагүй боловч, сул орон тоо нөхөх, албан тушаалын тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг шийдвэрлэсэн болно. Үүний үр дүнд гаалийн болон хорио цээрийн эрсдэлийг нэгдсэн байдлаар тооцох боломж бүрдэх юм. · <u>Хүний нөөц (дүнд):</u> Тус хэлтсийн орон тоо бүрдсэн боловч нэг ГУБ-ийн багшаар ажиллах, системийн хэмжээнд албан хаагчдыг англи хэлтэй болгох хүсэл эрмэлзлэлтэй нь уялдуулан нөөцийн үр дүнтэй хуваарилалт хийж СТ-д багшаар шилжүүлэн ажиллуулсан тул одоогоор нэг ГУБ-ийн орон тоо дутуу байна. Харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага, хорио цээрийн хяналт хариуцсан албан хаагчдыг түр хугацаагаар ажиллуулах боломжийг бүрдүүлж, БӨГГ-ын ГУБ түр хугацаагаар ажилласан ба УХШИГГ, УБГГ-ын ГУАБ, ГУБ нар тус хэлтэст түр ажиллаж байна. ЭУХ-ийн 2024 оны эхний хагас жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахтай холбоотой эрсдэлийг бууруулах зөвлөмж өгч, гүйцэтгэлийн чанар, нэгжийн дотоод уялдаа холбоог сайжруулсан.		
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”							
18	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	ЭУХ-ийн чиг үүргийн хүрээнд удирдлагаас өгсөн	01.01-06.05	100
19	ХГГХ-д хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	Харьяа гаалийн газар, хороодод “Эрсдэлийн удирдлага, худалдааг хөнгөвчлөх, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих; Гаалийн хяналтын төлөв; ОХУ-тай ХГА-тай	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					эрсдэлийн удирдлагын чиглэлээр хамтран ажиллах санал авах” гэсэн гурван үүрэг даалгаврыг ГЗДАС программаар хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. · Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээнээс чиг үүргийнхээ хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан ба харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад зөвлөмж чиглэлээр хангаж, зорилтот түвшинг тодорхой бодитой, улирал бүрт зөв хуваарилан төлөвлөхөд дэмжлэг үзүүлсэн. · Гаалийн мэдүүлгийн шалгалтын үр дүнгийн саналд дүн шинжилгээ хийж, санал бичилтийг үр дүнтэй бичүүлж хэвшүүлж, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох зорилгоор судалгааны формат гарган, гаалийн газар, хороодод хүргүүлж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан. · ОХУ-тай хиллэдэг УВГГ, ДОГГ, СЭГГ, ЗАГХ, ХӨГХ, БӨГГ, УБГГ-аас биелэлт илгээж, холбогдох саналыг авч хамтран ажилласан. “Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар, Оросын Холбооны Улсын Холбооны Гаалийн Алба Хоорондын Эрсдэлийн Удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцээр” (Цаашид “Эрсдэлийн удирдлагын хэлэлцээр” гэх)-ийн хэрэгжилтийг хангах асуудлаар шинжээчдийн анхдугаар уулзалтыг 2024 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд ГЕГ-т зохион байгуулж, төлөвлөгөөг 9 асуудлаар боловсруулан, дараагийн уулзалтыг 2025 онд ОХУ-д зохион байгуулахаар болсон. · ГУБ нарын шалгалтын үр дүнгийн санал бичилт сайжирч байна. Судалгаанд тоймлон оруулсан болно. ЗУГ-аас ГУБ-ийн ажлын үр дүнг тооцоход шалгалтын үр дүнгийн санал бичилтийг нэг шалгуур үзүүлэлт болгохоор болсон. · Бичиг баримт хариуцсан ГУБ болон хяналт, шалгалт хариуцсан ГУБ нараас ирүүлсэн ААН болон гаалийн мэдүүлэгт бүрдүүлэлтийн дараах шалгалт оруулах саналыг судалж, БДШГ-т дотоод зурвасаар хүргүүлж хэвшсэн. · Гаалийн хяналтын “ногоон”, “улбар шар” төлөвийг “Улаан” төлөвд өөрчилсөн нь өнгөрсөн оны үеэс 6 дахин буурсан. Гаалийн бүрдүүлэлтийн гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь 0.3%-ийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 95 мэдүүлгээр буурсан үзүүлэлттэй байна.		
20	Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних програмд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	96%	50%	· Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар тушаалаар ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь батлагдсан. ГЕГ-ын ЗББНДБ, орон	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна.				тоог ГЕГ-ын даргын А/23 дугаар тушаалаар баталсан. Тус хэлтэс нь дарга, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч долоо, нийт есөн хүний бүрэлдэхүүнтэй батлагдаж, хэлтсийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. · Тайлант хугацаанд тус хэлтэст ажиллавал зохих 9 албан хаагчаас хоёр орон тоо дутуу ажилласан. Нийт албан хаагчдын ажиллавал зохих 1,494 хүн өдрөөс ажилласан 1,486 хүн өдөр, өвчтэй 7 хүн өдөр байна. Ажлын шаардлагаар түр хугацаагаар болон бусад нэгжид шилжсэн албан хаагчийг хасвал ажлын цаг ашиглалт 99 хувь ажилласан. Ажлын шаардлагаар СЭГГ-ын ГУБ Т.Тэмүүлэнг тус хэлтэст түр хугацаагаар ажилуулсан.		
21	Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	70%	50%	· Хэлтсийн ГУАБ, ГУБ нарын ажил үүргийн хуваарийг, хяналтын ачаалал, гадаад худалдааны барааны чиг хандлага, газар зүйн онцлог зэрэгтэй уялдуулан шинэчилсэн. Тайлант хугацаанд харьяа гаалийн газар, хороодыг дараах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан. · “Гаалийн байгууллага 2024 онд” танилцуулга; Гаалийн газар, хороодын орчны судалгаа; Шалгалтын үр дүнгийн санал; Мэдүүлэг буцаалт, гаалийн хяналтын төлөв өөрчлөлтөд хэрхэн дүн шинжилгээ хийх тухай; Эрсдэл тооцох арга зүй; удирдлага” · “Risk management 2023-2024” групп нээж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албаны дарга, ГУАБ, ГУБ нарыг шуурхай мэдээллээр ханган ажилласан. · ГЕГ-ын ЭУХ, харьяа гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан албан хаагчид судалгаа, дүн шинжилгээ хийх, гаалийн хяналтын төлөвт дүн шинжилгээ хийх, аж ахуйн нэгж, иргэдийн хууль сахилтыг тодорхойлох болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр оны эхнээс 63 зураг, хүснэгт, ворд файл солилцож ажилласан. · ДГБ-ын 2024 оны уриа, ГЕГ-ын 2024 оны зорилттой уялдуулан гадаад худалдааг хөнгөвчлөх, эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг зохион байгуулах, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрхэн ажиллах чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод цахим хэлбэрээр хүргүүлж, мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. · “Гадаад худалдааны орчны судалгаа 2018-2022”-ыг хийсэн загварын дагуу тухайн гаалийн газар, хорооны хяналтын объектыг харуулсан 2021-2023 оны судалгааг хийж, эрсдэлт орчноо тодорхойлоход дэмжлэг үзүүлж, үүнийн үр дүнд гаалийн газар, хороод өөрсдийн эрсдэлт орчныг тодорхойлсон судалгаа хийж, ирүүлж хэвшсэн. · Шалгалтын үр дүнгийн саналд хэрхэн дүн шинжилгээ хийх зөвлөмжийг ГУБ нар хариуцсан гаалийн газар, хороодод тухай бүр өгч ажилласны үр дүнд шалгалтын үр дүнг худал, буруу бичих эрсдэл	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					буурсан. Түүнчлэн шалгалтын үр дүнгийн саналыг үнэн зөв бичиж байгаа эсэх шалгуурыг ГУБ нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд оруулах саналыг ЗУГ-т хүргүүлсэн. · Өдөр бүр, долоо хоног, сар, өссөн дүнгээр гаалийн хяналтын төлөвийн судалгааг хэрхэн хийх форматыг гарган харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нарт хүргүүлж, системийн хэмжээнд нэг загвараар гаалийн хяналтын төлөвийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх боломжийг боломжийг бүрдүүлсэн. · Эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ нар мэдүүлэг засварт буцаалтад дүн шинжилгээ хийж, бичиг баримтын болон хяналт хариуцсан ГУБ нарт зөвлөмж, чиглэл өгч ажилласнаар мэдүүлэг засварт буцаах эрсдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурсан. · Тайлант хугацаа (2024.06.10)-нд хяналтын “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 36 мэдүүлгийг “Улаан” төлөвд өөрчилсөн байна. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (2023.06.10: “ногоон”, “улбар шар” төлөвийн нийт 213 мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн) төлөв өөрчлөлт 6 дахин буурсан үзүүлэлттэй байна.		
22	Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдлыг тайлагнасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	70%	50%	· Тус хэлтсийн албан хаагч нар тайлант хугацаанд үндсэн чиг үүрэгтэй холбоотой 15 уулзалт, 6 сургалт, цаг үеийн шинжтэй бусад 6 уулзалт, 6 сургалт, нийт 33 арга хэмжээнд оролцсон. Мөн Гаалийн байгууллагын мэдээллийн цаг хөтөлбөрт 10, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар сургалтад 11 удаа, нийт 22 удаагийн мэдээллийн цагт оролцсон.	01.01-06.05	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1	Гаалийн байгууллагын ёс зүйг бэхжүүлэх чиглэлээр ДГБ-ын бодлого, чиглэлийг судлан, мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төрийн албанаас зохион байгуулсан богино хугацааны цахим сургалт, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтын үеэр ерөнхий	ДГБ-ын Ёс зүйн цахим сургалтад хамрагдсан байна.	- ГЕГ-ын албан хаагч нараас авсан санал асуулгын үр дүнгээр ГЕГ-ын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг ГЕГ-ын даргын 2024.04.24-ний өдрийн А/212 дугаар тушаалаар баталсан. - Гаалийн байгууллагын мэдээллийн customs.gov.mn цахим хуудасны Ил тод байдал хэсэгт Ёс зүйн дэд хороо гэсэн цэсийг шинээр үүсгэн, дэд хорооны албаны үйл ажиллагаанд ашиглах ethic@customs.gov.mn цахим шуудангийн хаягтай болсон. - Төрийн албаны зөвлөлөөс өгсөн зөвлөмж, хууль тогтоомжоос харахад Ёс зүйн дэд хороог гаалийн газар, хороодод байгуулах шаардлагатай байна. Иймд нэгдсэн чиглэл авахаар Төрийн албаны зөвлөлд цахим захидал илгээсэн.	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
			мэдлэгтэй болсон.				
2	Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр ДГБ-аас хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг судлах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Ерөнхий мэдээлэлтэй.	Ази, Номхон далайн бүс нутгийн хүрээнд Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй санаачилгаас суралцаж, ЗДА-ын систем программд холбогдох мэдээллийг нэгтгэн, албан хаагчдад хүргэсэн байна.	“ДГБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн гаалийн дарга нарын 25 дугаар дээд хэмжээний уулзалт”-д оролцсон тайланд “Ази, Номхон далайн бүс нутгийн хүрээнд Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах” чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг оруулж, ГЗДАС-ийн “Гадаад арга хэмжээ” дэд талбарт байршуулж, гаалийн албан хаагч нарт түгээсэн (Хандалтын тоо 50). - ДГБ-ын Хүйсийн тэнцвэрт болон олон талт байдлын ажлын хэсэгт ГЕГ-ын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, СТ-ийн багш Ж.Жаргал-Эрдэнэ нар орж ажиллаж байна. - Ажлын хэсгийн 2024.06.05-нд цахим хэлбэрээр явагдсан анхны хурлын үеэр ДГБ-ын Нарийн бичгийн даргын газраас танилцуулсан “Гаалийн байгууллагад Жендерийн эрх тэгш болон ялгавартай байдал” сэдэвт танилцуулгыг ГЗДАС-ийн “Худалдааг хөнгөвчлөх” дэд талбарт байршуулсан. - ГЕГ-ын “Жендерийн эрх тэгш болон ялгаатай байдал”-ын үнэлгээг хийж ДГБ-ын ажлын хэсэгт 8 дугаар сард хүргүүлэхтэй уялдуулан - Үүнтэй уялдуулан ГЕГ-ын Ёс зүйн дэд хороо, Сургалтын төв, Хүний нөөцийн хэлтэстэй хамтран дээрх үнэлгээг хийхээр төлөвлөж байна.	01.01-06.05	100
2	Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт: Төрийн албаны зөвлөлийн 11 удаагийн цахим сургалтад хамрагдаж, дараах мэдээллийг олж авсан. - Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг "Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах" - МУИС-ийн Профессор А.Энхбаяр, VR AR MR "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" – МУИС-ийн зөвлөх, ЭЗШУ-ны доктор, профессор Л.Оюун "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа" "Төрийн албаны үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал" - МУИС-ийн ахлах багш, доктор Г.Мягмар "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)" - "Чингис хаан" музейн захирал, ШУА-ийн гишүүн, академич, түүхийн шинжлэх ухааны доктор С.Чулуун "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга" "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга	01.01-06.05	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					9. “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа” 10. “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” 11. “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь”		

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ (Д.ЦЭНДСҮРЭН)

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ДАВААГИЙН ЦЭНДСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		64.9

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Гаалийн байгууллагын ёс зүйг бэхжүүлэх чиглэлээр ДГБ-ын бодлого, чиглэлийг судлан, мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх		15
2	Жендерийн тэнцвэрт болон олон талт байдлыг хангах чиглэлээр ДГБ-аас хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг судлах		15
3	Төрийн албанаас зохион байгуулж буй цахим сургалтад тухай бүр хамрагдах		15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	15
2	Удирдан зохион байгуулах	15
3	Асуудал шийдвэрлэх	15
4	Манлайлах	15
5	Багаар ажиллах	15
6	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	64.9

2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	15
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		94,9

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч

(Р.Отгонжаргал)

2024.06.19 (огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

/Эрсдэлийн удирдлагын
Хэлтсийн даргын албан үүргийг
Түр орлон гүйцэтгэгч/

(Д.Цэндсүрэн)

2024.06.22 (огноо)